



# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

2023-III

»

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ,  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН  
ТАНИЛЦУУЛГА

2023

3 сар

Улаанбаатар хот  
2023



ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО

# СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН


Хайх ...



**СТАТИСТИКИЙН** мэдээллээ аваарай

**Data lab**

тооллого судалгааны  
микро мэдээллийн сан



**Social network**



**/StatisticMGL**

**Лавлах утас**



**1900-1212**

**Цахим шуудан**



**information@nso.mn**

**I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.**


- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

**II. Дараах тэмдэглэгээг ашиглав.**

- ... мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- - гүйцэтгэл байхгүй
- \* урьдчилсан гүйцэтгэл

**III. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ**

- мянга =1000
- сая =10<sup>6</sup>
- тэрбум =10<sup>9</sup>
- их наяд =10<sup>12</sup>
- мян. мянга
- % хувь
- мм миллиметр
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- м<sup>2</sup> метр квадрат
- дм<sup>2</sup> дециметр квадрат
- км<sup>2</sup> километр квадрат
- м<sup>3</sup> метр куб
- га гектар
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- цн центнер
- т тонн
- Вт ватт
- кВт.ц киловатт цаг
- кал калори
- ккал килокалори
- Гкал гигакалори(=10<sup>9</sup> калори)
- с секунд
- мин минут
- мкг/м<sup>3</sup> микрограмм метр куб
- м/с метр секунд
- ш ширхэг
- х.д.х хэвлэлийн даралтат хуудас

-  Үүнээс гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

**IV.** Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



**V.** Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



**VI.** Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

## ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл.....	4
Үндсэн үзүүлэлт.....	5-6
I.Нийгмийн даатгал.....	7-10
II.Боловсрол.....	11
III.Эрүүл мэнд.....	12-15
IV.Гэмт хэрэг .....	16-19
V.Дүүргийн төсөв.....	20-23
VI.Хэрэглээний үнэ.....	24-26
VII.Дүүргийн аюулгүй байдал.....	27-28
VIII.Аж үйлдвэр.....	29-33
IX.Нийтийн аж ахуй .....	35
X.Төрийн бусад үйлчилгээ.....	36-41

## БҮЛЭГ

## ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

	Үндсэн үзүүлэлтүүд /хүснэгт/	Г.Пүрэвсүрэн
I	Нийгмийн даатгал,халамж	Т.Хишигбаяр
II	Боловсрол	Ч.Уртнасан
III	Эрүүл мэнд	Б.Цогбаясгалан
IV	Гэмт хэрэг	Г.Пүрэвсүрэн
V	Дүүргийн төсөв	Г.Пүрэвсүрэн
VI	Хэрэглээний үнэ	Ч.Уртнасан
VII	Дүүргийн аюулгүй байдал	Г.Пүрэвсүрэн
VIII	Аж үйлдвэр	Б.Цогбаясгалан
IX	Нийтийн аж ахуй	Ч.Уртнасан
X	Төрийн бусад үйлчилгээ	Т.Хишигбаяр

## ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, дүүргээр, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 I-III	2023 I-III	Өөрчлөлт хувь
Шинэ төрсөн хүүхэд	тоо	587	591	0.7%
Халдварт өвчнөөр	тоо	94	42	-55.3%
Дүүргийн төсвийн орлого	тэрбум.төг	21.4	45.5	1.2 <sup>1</sup>
Дүүргийн төсвийн зарлага	тэрбум.төг	21.4	41.3	0.9 <sup>1</sup>
Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт	пункт	0.9	2.9	2.2%
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, сарын эцэст	1US\$ =₮	3 061.2	3 483.8	13.8%

## ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН 2022 ОНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн дундаж ам бүлийн тоо <sup>1</sup>	Хүн ам зүйн ачаалал <sup>2</sup>
<b>Дүүргийн дүн</b>	<b>37 246</b>	<b>144 249</b>	<b>3.9</b>	<b>58.1</b>
1 -р хороо	881	3 804	4.3	67.4
2 -р хороо	940	3 399	3.6	66.0
3 -р хороо	1 571	6 1221	3.9	66.1
4 -р хороо	1 246	5 300	4.3	60.3
5 -р хороо	1 164	4 626	4.0	58.2
6 -р хороо	2 367	9 254	3.9	64.8
7 -р хороо	1 757	6 611	3.8	55.0
8 -р хороо	940	3 658	3.9	56.3
9 -р хороо	1 594	6 244	3.9	52.8
10 -р хороо	1 717	7 074	4.1	56.6
11 -р хороо	1 249	4 863	3.9	53.7
12 -р хороо	1 627	6 729	4.1	55.8
13 -р хороо	1 761	6 983	4.0	58.5
14 -р хороо	1 674	6 461	3.9	57.7
15 -р хороо	2 094	8 524	4.1	59.0
16 -р хороо	1 979	7 808	3.9	56.8
17 -р хороо	2 131	7 907	3.7	56.9
18 -р хороо	2 220	7 865	3.5	54.1
19 -р хороо	2 014	7 456	3.7	57.0
20 -р хороо	1 392	5 223	3.8	55.0
21 -р хороо	1 728	7 027	4.1	57.2
22 -р хороо	1 039	4 021	3.9	58.4
23 -р хороо	1 263	4 509	3.6	57.8
24 -р хороо	898	2 782	3.1	62.4

<sup>1</sup> Нэг өрхөд ногдох ам бүлийн дундаж тоо

<sup>2</sup> Нэг километр квадрат газар нутагт ногдо хүний тоо

<sup>3</sup> 15-64 насны 100 хүнд ногдох хүүхэд, өндөр настны тоо






## НИЙГМИЙН ДААТГАЛ, 2023 оны эхний 03 сарын байдлаар

2023 оны эхний 03 сарын байдлаар

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, сая төгрөг




\* ҮОМШӨ - үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин


### НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД

Албан журмаар даатгуулагчид

Сайн дураар даатгуулагчид



### ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧИД






## I. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ


Нийгмийн даатгалын сангийн орлого энэ оны 3 сард 149.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 47.4 (46.3%) тэрбум төгрөгөөр, сангийн зарлага 149.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 45.4 (43.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 1.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сангуудаар, сая төгрөг,



Сангуудаар авч үзвэл өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн орлого 33141.6 (48.0%) сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 3333.8 (46.5%) сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 6464.5 (38.8%) сая төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 3735.9 (45.9%) сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 741.8 (51.0%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 1.2 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар,



ЗУРАГ 1.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сангуудаар, сая төгрөг,




Өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн зарлага 35117.7 (43.5%) сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 3152.1 (43.9) сая төгрөгөөр, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зарлага 3752.0 (46.2) сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 1114.6 (97.6%) сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 2261.4 (10.8%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийгмийн халамжийн сангаас энэ оны 03 дугаар сард 100.2 мянган хүнд 22.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 1.3 (1.3%) мянган хүнээр өсөж, олгосон тэтгэвэр, тэтгэмж 1.2 (5.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт энэ оны 3 сарын байдлаар 2 445 хүн хамрагдаж 1937.6 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 59 (2.5%)-аар, олгосон мөнгөн тэтгэвэр 9.8 (0.5%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 1.4 ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, тэрбум төгрөг



Нийгмийн халамжийн тэтгэмжид 67059 хүн хамрагдаж 18.2 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 80 (22.1%) мянган хүнээр, олгосон тэтгэмж 56.5 (18.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Асаргааны тэтгэмжид 2867 хүн хамрагдаж 724.9 сая төгрөгийн тусламж олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 71 (2.5%)-аар, олгосон тэтгэмж 57.3 (8.6%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

**Ойлголт, тодорхойлолт**

**Нийгмийн даатгал:** Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

**Нийгмийн даатгалын сан:** Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

**Даатгуулагч:** Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

**Тэтгэвэр:** Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

**Тэтгэмж:** Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна. Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.



## II. БОЛОВСРОЛЫН САЛБАР

Дүүргийн хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилийн ерөнхий боловсролын сургуульд суралцагчдийн тоо 29054 болж өмнөх оны мөн үеэс 2122 (7.9%) хүүхдээр нэмэгдсэн байна. 2021-2022 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд нийт 12 890 хүүхэд хамрагджээ.

### ХҮСНЭГТ 2.1 ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЕБС-Д СУРАЛЦАГЧДЫН ТОО, ХҮЧИН ЧАДАЛ

Сургууль	2020-2021 оны хичээлийн жил				2021-2022 оны хичээлийн жил			
	Хүчин чадал	Хүүхдийн тоо	Бүлэг дүүргэлт	хүчин чадал хэтрэлт %	Хүчин чадал	Хүүхдийн тоо	Бүлэг дүүргэлт	хүчин чадал хэтрэлт %
<b>БҮГД</b>	<b>13 410</b>	<b>26 932</b>	<b>563.5</b>	<b>3069.2</b>	<b>14 020</b>	<b>29 054</b>	<b>36.6</b>	<b>109.7</b>
5-р сургууль	960	3 311	47.9	344	1 200	3 379	45.6	39.3
17-р сургууль	1 240	2 298	36.0	185.3	1 240	2 316	53.5	36.2
23-р сургууль	1 280	3 588	53.6	280.3	1 240	3 592	34.5	53.6
24-р сургууль	920	3 636	32.0	264.6	1 370	3 747	36.6	43.1
37-р сургууль	1 200	1 915	31	395.2	1 200	1 976	60.7	30.4
39-р сургууль	1 060	1 750	36.5	165.1	1 100	1 839	59.8	36.0
49-р сургууль	960	1 201	29.3	125.1	960	1 232	77.9	29.3
50-р сургууль	1 370	2 556	42.6	186.6	1 370	2 634	58.0	42.5
57-р сургууль	920	1 430	31.8	155.4	920	1 479	62.2	32.2
61-р сургууль	720	886	30.6	123.1	720	915	78.7	30.5
72-р сургууль	1 400	2 086	37.3	149	1 400	2 230	62.8	34.8
112-р сургууль	120	97	16.2	80.8	120	82	146.3	11.7
117-р сургууль	720	1 490	30.4	206.9	640	1 462	43.8	29.8
138-р сургууль	180	311	26.0	172.8	180	315	57.1	22.5
139-р сургууль	180	545	36.3	0.03	180	545	33.0	33.0
140-р сургууль	180	423	32.5	235	180	434	41.5	33.4
149-р сургууль	-	-	-	-	720	758	20.1	103.5
СУИС-ийн харьяа Бадмаараг ахлах сургууль	-	279	-	-	-	270	-	22.5
Хувийн	-	1 216	13.5	-	-	1 216	13.5	-

### ХҮСНЭГТ 2.2 ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН ТОО, ХҮЧИН ЧАДАЛ

Үзүүлэлт	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022
2-5 настай хүүхэд	15 077	15 565	14 585	7 336	12 890
СӨБ-д хамрагдсан	11 386	11 185	10 584	7 336	12 890
Хүчин чадал	5 985	6 912	7 580	4 001	8 445
Хүчин чадал хэтрэлт	90.2	61.6	39.6	83.3	71.5
Цэцэрлэгийн тоо	55	58	53	50	54
Үүнээс: Улсын цэцэрлэг	29	28	31	32	39
Хувийн цэцэрлэг	26	30	22	18	15



## ЭРҮҮЛ МЭНД, 2023 оны эхний 3 сарын байдлаар

ЭМНЭЛЭГТ ХЭВТЭН  
ЭМЧЛҮҮЛЭГЧИД

Эмнэлэгт хэвтэн  
эмчлүүлэгчид



2022 I-III 1 128

2023 I-III 2 795 **51.0%** ↑



Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



2022 I-III 10 139

2023 I-III 252 **29.2%** ↓



Нялхсын эндэгдлийн түвшин

2022 I-III 3.4

2023 I-III 1.7

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн  
түвшин (1000 амьд төрөлтөд ногдох)

2022 I-III 1.7

2023 I-III 1.4



### III. ЭРҮҮЛ МЭНД


Дүүргийн эрүүл мэндийн төвийн мэдээгээр 2023 оны 03 сард 588 эх амаржиж, 591 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс төрсөн эх 44 (12.9%)-аар, мэндэлсэн хүүхэд 43 (12.5%) -аар өссөн байна.

#### ХҮСНЭГТ 3.1 ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, эхний 03 сард

Үзүүлэлт	2021 I-III	2022 I-III	2023 I-III	Өсөлт, бууралт 2022-2023	
				Тоо	Хувь
Амаржсан эхийн тоо	784	581	588	44	12.9%
Амьд төрсөн хүүхэд	794	587	591	43	12.5%
Нас барсан хүн	200	214	202	-14	-10.7%
Эхийн эндэгдэл	0	0	0	-1	-25.0%
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	9	6	4	-3	-60.0%
1-5 настай хүүхдийн эндэгдэл	0	1	2	1	100.0%
Амьгүй төрөлт	3	2	1	1	100.0%
Гэрийн төрөлт	1	0	1	0	0.0%
Хяналтгүй төрөлт	3	1	2	-3	75.0%

2023 оны 03 сард 111304 хүн үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 26 333 (29.6%)-аар өссөн байна. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 1 824 болж 194 (11.9%) хүнээр өсчээ.

#### ЗУРАГ 3.1 ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



## ХҮСНЭГТ 3.2 ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, эхний 3-р сард

Төрөл	2021 III		2022 III		2023 III		Өөрчлөлтийн хувь 10 000 хүнд ногдох
	Бодит тоо	10 000 хүнд ногдох	Бодит тоо	10 000 хүнд ногдох	Бодит тоо	Бодит тоо	
<b>Дүүргийн дүн</b>	<b>282</b>	<b>18.65</b>	<b>9665</b>	<b>639.34</b>	<b>Дүүргийн дүн</b>	<b>171</b>	<b>11.33</b>
Гепатит	1	0.07	1	0.07	Гепатит	8	0.53
Цусан суулга	1	0.07	8	0.53	Цусан суулга	12	0.80
Сальмоненнез	0	0.00		0.00	Сальмоненнез	2	0.13
Хоолны хордлого	0	0.00	1	0.07	Хоолны хордлого	0	0.00
Менингококкт	0	0.00		0.00	Менингококкт	0	0.00
Салхин цэцэг	0	0.00	10	0.66	Салхин цэцэг	73	4.84
Гахайн хавдар	0	0.00		0.00	Гахайн хавдар	0	0.00
Улаан эсэргэнэ	0	0.00	1	0.07	Улаан эсэргэнэ	1	0.07
Ёлом	0	0.00		0.00	Ёлом	1	0.07
Хумхаа	0	0.00	0	0.00	Хумхаа	0	0.00
Бруцеллэз	0	0.00	0	0.00	Бруцеллэз	0.00	3
Гар, хөл, ам	0	0.00	0	8	Гар, хөл, ам	0.53	89
Эритема	0	0.00	0	0.00	Эритема	0.00	1
Ковид-19	175	11.58	9 547	631.54	Ковид-19	0	0
Энтэровируст халдварт	0	0.00	0	0.00	Энтэровируст халдварт	0	0.00
Бусад	0	0.00	0	0.00	Бусад	0	0.00
Тэмбүү	52	3.44	27	1.79	Тэмбүү	27	1.79
Төрөлхийн тэмбүү	0	0.00	0	0.00	Төрөлхийн тэмбүү	0	0.00
Заг хүйтэн	15	0.99	11	0.73	Заг хүйтэн	5	0.33
Сүрьеэ	20	1.32	30	1.98	Сүрьеэ	24	1.59
Мөөгөнцөр	5	0.33	9	0.60	Мөөгөнцөр	3	0.20
Трихомониаз	13	0.86	20	1.32	Трихомониаз	10	0.66

Бэлгийн замын халдварт өвчин 42 болж, Мөн нийт халдварт өвчний 24.6 хувийг эзэлж байна. Мөн Ковид-19 халтварт өвчин нэг ч бүртгэгдээгүй байна.



**Ойлголт, тодорхойлолт:**

**Амьд төрөлт:** Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

**Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):** Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):** Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):** Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох):** Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Эндсэн эх:** Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



## ГЭМТ ХЭРЭГ, 2023 оны эхний 3 сарын байдлаар

ᠮᠤᠩᠭᠡᠨ



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

2022 I-III


1 864

2023 I-III

2 848

52.8% ↑

Дүүргээр



Гэмт хэргийн улмаас



Хохирсон хүн

786



Гэмтсэн хүн

132



Нас барсан хүн

4



## IV.ГЭМТ ХЭРЭГ


2023 оны 3 дугаар сард дүүргийн хэмжээнд нийт 831 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 84 (9.2%) хэргээр буурсан байна. Нийт гэмт хэргийн 152 (24.7%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 5 (0.6%) нь хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг хэрэг, 15 (1.8%) нь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг хэрэг, 149 (17.9%) нь хулгайн хэрэг, 10 (1.2%) нь дээрэмдэх хэрэг, 387 (46.6%) нь залилан мэхлэх гэмт хэрэг, 24 (2.9%) нь алдаатай гүйлгээ, гээгдсэн хөрөнгө завших хэрэг, 14 (1.7%) нь мөрийтэй тоглоом зохион байгуулах, 7 (0.8%) нь автотээврийн ХАБ, АЖ зөрчих гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 4.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, цагдаагийн хэлтсээр, төрлөөр

Дүүргийн дүн	2022 I-III	2023 I-III	Үүнээс: Цагдаагийн		Өсөлт бууралт	
	915	831	I хэлтэс 325	II хэлтэс 396	Тоо 84	Хувь 9.20%
Хүнийг алах /10.1/	3	5	1	5	-2	-66.7
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх /10.4/	6	2	2	0	-4	0.6%
ХЭМ-ийн халдашгүй байдлын эсрэг /11.1-11.7/	183	152	78	74	-31	-16.9%
Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл	2	2	1	1	-	-
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг/12.1-5	5	5	1	4	-	-
Үүнээс: Хүчиндэх /12.1/	4	4	-	4	-	-
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг 13.1-13.13	4	15	15	-	11	2.8%
Хулгайлах /17.1/	135	149	77	72	35	10.4%
Дээрэмдэх /17.2/	7	10	3	7	-3	42.9%
Залилан мэхлэх /17.3/	492	387	184	203	-105	-21.3%
Хөрөнгө завших /17.4/	-	-	-	-	-12	-
Алдаатай гүйлгээ, ... гээгдэл эд хөрөнгө, ... завших /17.5/	11	24	15	4	13	1.8 <sup>1</sup>
Мөрийтэй тоглоом зохион байгуулах /20.17/	6	14	-	-	8	1.3 <sup>1</sup>
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг /20.1-20.17/	-	-	10	4	-	-
Автотээврийн хэрэгслийн ХАБ, АЖ зөрчих /27.10/	18	7	7	-	-11	-61.1%
Бусад	25	-	-	-	-25	-1.0%

\*Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газрын мэдээллээс

ЗУРАГ 4.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар





**Ойлголт, тодорхойлолт:**

**Гэмт хэрэг:** Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

**16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг:** Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

**Хохирогч:** Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.




**Гэмт хэргийн хохирол:** Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

**Яллагдагч:** Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.



## ДҮҮРГИЙН ТӨСӨВ, 2023 оны 3 сарын эхний байдлаар

ᠳᠦᠭᠦᠷᠭᠢᠨ  
ᠲᠥᠰᠥᠪ






## V. ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нэгдсэн тэнцэл 2023 оны 3 дугаар сард 4.2 сая төгрөг гарсан байна.


ЗУРАГ 5.1 ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн 3 сард



Дүүргийн төсвийн нийт орлого 2023 оны 3 дугаар сард 45.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 2.0 тэрбум төгрөгөөр (4.6%) илүү бүрджээ. Төсвийн нийт орлогын 98.0 хувийг татварын орлого, 1.4 хувийг татварын бус орлого эзэлж байна.

2023 оны 3 сард дүүргийн татварын орлого 44.2 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 2.0 тэрбум төгрөгөөр буюу 4.6 хувиар илүү, татварын бус орлого 634.8 сая төгрөгт хүрч төлөвлөснөөс 132.4 сая төгрөгөөр (17.3%) дутуу бүрдсэн байна.

ЗУРАГ 7.2 ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сараар, сая төгрөгөөр



ХҮСНЭГТ 5.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөгөөр, 2023 оны 3 сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>43 460.3</b>	<b>45 462.7</b>	<b>2 002.4</b>	<b>4.6%</b>
А. Урсгал орлого	43 199.2	45 201.6	2 002.4	4.6%
1. Татварын орлого	42 431.9	44 566.8	2 134.9	5.0%
1.1. Орлогын албан татвар	37 534.0	33 707.4	-3 829.6	-10.2%
1.2. Өмчийн татвар	1 118.0	1 439.4	321.4	28.8%
1.3. Бусад татвар (төлбөр хураамж)	3 777.0	9 419.9	5 643.0	1.4дахин
2. Татварын бус орлого	767.3	634.9	-132.4	-17.3%
Б. Хөрөнгийн орлого	-	-	-	-
В. Тусламжийн орлого	261.1	261.1	-	-

\*Эх үүсвэр: ЧД-ийн Санхүү, төрийн сангийн хэлтэс


Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх дүн 2023 оны 3 дугаар сард 41.2 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 8.7 тэрбум төгрөг (17.5%) хэмнэсэн байна. Төсвийн нийт зарлагын 4.7 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 0.6 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 20.3 хувийг бараа, үйлчилгээний бусад зардал, 71.1 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

ХҮСНЭГТ 5.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөгөөр, 2023 оны 3 сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>49 970.0</b>	<b>41 250.0</b>	<b>-8 720.1</b>	<b>-17.5</b>
А. Урсгал зарлага	43 870.1	39 842.6	-4 027.5	-9.2
1. Бараа, үйлчилгээний зардал	14 278.8	10 523.0	-3 755.8	-26.3
1.1. Цалин, хөлс	2 567.4	1 929.2	-638.3	-24.9
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	349.2	239.8	-109.3	-31.3
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	11 362.2	8 354.1	-3 008.2	-26.5
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	29 591.2	29 319.5	-271.7	-0.9
3.1. Татаас	-	-	-	-
3.2. Урсгал шилжүүлэг	29 591.2	29 319.5	-271.7	-0.9
Б. Хөрөнгийн зардал	6 100.0	1 407.4	-4 692.6	-76.9
Хөрөнгө оруулалт	6 100.0	1 407.4	-4 692.6	-76.9

\*Эх үүсвэр: ЧД-ийн Санхүү, төрийн сангийн хэлтэс

ЗУРАГ 5.3 ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сараар, сая төгрөгөөр





Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, ирээдүйн өв сангийн төсөв эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого: Тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.


Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.



## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН УЛСЫН ИНДЕКС, бүлгээр, хувиар, 2023 оны эхний 3 сарын байдлаар

ӨНДӨН АЖААЛЫН  
 ХУВИАР  
 ХУВЦАС, БЭС,  
 БАРАА, ГУТАЛ  
 ТЭЭВЭР  
 ХУВЦАС, БЭС,  
 БАРАА, ГУТАЛ  
 АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ,  
 СОЁЛЫН БАРАА  
 ҮЙЛЧИЛГЭЭ  
 СОГТУУРУУЛАХ  
 УНДАА, ТАМХИ  
 ОРОН СУУЦ, УС,  
 ЦАХИЛГААН, ТҮЛШ






## VI.ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2023 оны 3 дугаар сарын хэрэглээний үнийн индекс 2022 оны эцэстэй харьцуулахад 3.6 хувь, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.1 хувиар өссөн байна.

ЗУРАГ 6.1 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, сараар



Хэрэглээний үнийн индекс 2023 оны 3-р сард өмнөх оны эцэстэй харьцуулахад 3.6 хувиар өссөн ба үүнд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 8.3 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодисын бүлгийн үнэ 1.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын үнэ 1.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 1.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 3.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлэг 1.9 хувь, тээвэр 0.6 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ 0.6 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээ 2.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байр 8.1 хувь, бусад бараа үйлчилгээ 5.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 6.2 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2023 III 2022 III	2023 III 2022 XII	2023 III 2023 II
Ерөнхий индекс	112.1	103.6	101.0
Хүнсний бараа, ундаа, ус	115.6	108.3	102.3
Согтууруулах ундаа, тамхи	109.4	101.4	100.1
Хувцас, бөс бараа, гутал	115.7	101.9	99.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	119.6	101.9	100.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	113.6	103.7	102.2
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	107.0	101.9	100.8
Тээвэр	104.0	100.6	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	101.9	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	110.2	100.6	100.2
Боловсролын үйлчилгээ	110.7	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	119.1	108.1	105.7
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	108.4	102.8	100.0
Бусад бараа, үйлчилгээ	122.0	105.3	100.8

**Ойлголт, тодорхойлолт:**

**Хэрэглээний сагс:** Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно

**Хэрэглээний бараа, үйлчилгээний жин:** Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

**Хэрэглээний үнийн индекс:** Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

**Тооцох аргачлал:**

Хэрэглээний үнийн индексийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейрсийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left( \frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left( \frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left( \frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left( \frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

$I_{ct}^L$  – тайлант үеийн хувиргасан Ласпейрсийн индекс (t)

t – тайлант үе

i – бараа, үйлчилгээ

o – суурь үе

$P_t^i$  - i барааны тайлант үеийн үнэ

$P_0^i$  – i барааны суурь үеийн үнэ

$Q_0^i$  - i барааны суурь үеийн жин




## ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧИЛ, 2023 оны эхний 3 сарын байдлаар

Тээврийн хэрэгсэл жолоодсон

Торгуулсан жолоочийн тоо		Торгуулсан нийт хэмжээ /сая,төгрөг/	
2022 I-III	2023 I-III	2022 I-III	2023 I-III
6 102	28 570 <b>36.8% ↑</b>	255.7	754.3 <b>1.9% ↑</b>

НИЙТ ЗӨРЧИЛ 29 245





## VII. ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

**Зам тээврийн осол, зөрчил:** Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтсийн алба хаагчид 2023 оны 03 дугаар сард гудамж замд хийсэн хяналт шалгалтаар 8864 зөрчил илрүүлж, зөрчил гаргасан 8609 хүн, 228 хүнд торгож, эрх хасах, 35 хүнд шүүхээр баривчлах шийтгэл оногдуулж, 8609 жолоочийг 249.9 сая төгрөгөөр торгож ажиллав.

### ХҮСНЭГТ 7.1 ТОРГУУЛСАН ЖОЛООЧИЙН ТОО, торгуулийн хэмжээ

Торгууль	2021 I-III	2022 I-III	2023 I-III
Торгуулсан жолоочийн тоо	4 368	6 102	28 570
Торгуулийн нийт хэмжээ /сая төгрөг/	221.4	255.7	754.3

### ХҮСНЭГТ 7.2 ЗАМ ТЭЭВРИЙН ЗӨРЧИЛ, зөрчлийн хэлбэрээр

Зөрчлийн хэлбэр	2021 I-III	2022 I-III	2023 I-III
<b>НИЙТ ЗӨРЧИЛ</b>	<b>4 806</b>	<b>6 067</b>	<b>29 245</b>
Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон	350	309	624
Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, боловч тээврийн хэрэгсэл жолоодсон	64	35	254
Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон	325	-	2 184
Хамгаалах бүс хэрэглээгүй	129	-	1 151
Хориглосон нөхцөлөөр зогссон	1 055	-	8 782
Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн	9	-	4
Эгнээ байраа буруу эзэлсэн	538	-	684
Бусад зөрчил	2 336	4 126	15 562


2023 оны 3 сард эрэн сурвалжлагдаж байсан 14 иргэнийг илрүүлж харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн ажилласан.




## АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2023 оны эхний 3 сарын байдлаар

Уул уурхайн олборлолт аж үйлдвэр /сая төгрөг/


Уул уурхайн олборлолт аж үйлдвэр /сая төгрөг/



Боловсруулах аж үйлдвэр /сая төгрөг/



Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа /сая төгрөг/






## VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2023 оны 3 дугаар сарын байдлаар 3 017.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1 189.3 (28.3%) сая төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбар 219.5 (12.0%) сая төгрөгөөр, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 882.6 (72.0%) сая төгрөгөөр, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 87.7 (12.7%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 8.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сараар, тэрбум төгрөг



Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2023 оны 3 дугаар сарын байдлаар 807.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 882.6 (52.2%) сая төгрөгөөр буурсан байна үүнээс Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа 66.6 (45.3%) сая төгрөгөөр, Бусад боловсруулах үйлдвэрлэл 4.2 (17.3%) сая төгрөгөөр тус тус өссөн бол тавилга үйлдвэрлэл 86.9 (73.3%) сая төгрөгөөр, хувцас үйлдвэрлэл 371.2 (78.5%) сая төгрөгөөр, хүнс ундааны үйлдвэрлэл 400.2 (81.4%) сая төгрөгөөр, Ээрэх болон нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл 205.4 (47.6%) сая төгрөгөөр, буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын 2023 оны 3 дугаар сарын борлуулалт 3 307.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 870.3 (20.8%) тэрбум төгрөгөөр буурахад боловсруулах үйлдвэрлэлийн салбар 481.3 (32.1%) сая төгрөгөөр буурч, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 73.8 (12.0%) сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.



## ХҮСНЭГТ 8.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Салбар	Нийт бүтээгдэхүүн			Өсөлт/Бууралт		Бүтэц /хувиар/
	2021 III	2022 III	2023 III	Дүнгээр	Хувиар	
	Сая.төг	Сая.төг	Сая.төг			
<b>Нийт дүн</b>	<b>2 227.7</b>	<b>4 207.6</b>	<b>3 017.7</b>	<b>(1 189.9)</b>	<b>-28.3%</b>	<b>100.0%</b>
1 Уул уурхайн олборлолх аж үйлдвэр	906.5	1 826.0	1 606.5	(219.5)	-12.0%	53.2%
Нүүрс	-	-	102.2	102.2	-	
Өнгөт төмөрлөгийн хүдэр олборлолт	208.2	986.2	323.4	(662.7)	-	
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	698.3	839.8	1 180.8	341.0	40.6%	
2 Боловсруулах аж үйлдвэр	617.1	1 690.0	807.4	(882.6)	-52.2%	26.8%
Хүнс ундааны үйлдвэрлэл	-	491.4	91.2	(400.2)	-81.4%	
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	239.1	431.1	225.7	(205.3)	-47.6%	
Хувцас үйлдвэрлэл	212.6	472.9	101.7	(371.2)	-78.5%	
Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	-	-	78,6	78,6		
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	146.6	147.0	213.6	66.6	45.3%	
Модон, үйсэн, үртсэн болон холтсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл		-	15.1	15.1		
Тавилга үйлдвэрлэл	-	122.9	52.4	(70.4)	-57.3%	
Бусад боловсруулах үйлдвэрлэл	18.7	24.5	28.7	4.2	17.3%	
3 Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	703.9	691.5	603.8	(87.7)	-12.7%	20.0%
Хог хаягдал цуглуулах, зайлуулах	703.9	691.5	603.8	(87.7)	-12.7%	
Борлуулалтын орлого	2 780.9	4 177.9	3 307.5	(870.3)	-20.8%	109.6%

Энэ оны 3-р сарын байдлаар нийт үйлдвэрлэлийн уул уурхайн олборлох үйлдвэрлэл 1 606.5 (53.2%) сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 219.5 (12.0%) сая төгрөгөөр, боловсруулах үйлдвэрлэл 807.4 (26.8%) сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 882.6 (52.2%) сая төгрөгөөр, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 603.8 (20.0%) сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 87.7 (12.7%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.


ХҮСНЭГТ 8.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар

Салбар	2020 III	2021 III	2022 III	2023*		2023* III 2022 III
				III	Гадаадад	
	тэрбум төгрөг					
<b>Нийт дүн</b>	<b>48 588.7</b>	<b>2 131.7</b>	<b>4 177.9</b>	<b>3 307.5</b>	-	0.8
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	46 144.2	906.5	1 826.0	1 723.5	-	0.9
Боловсруулах аж үйлдвэр	1 668.3	521.2	1 660.3	980.1	-	0.6
Ус хангамж, сувагжилтын систем	776.1	703.9	691.5	603.8	-	0.9

<sup>1</sup> Дахин их

2023 оны 3-р сарын байдлаар уул уурхайн олборлох үйлдвэрлэл 102.5 (5.6%) сая төгрөгийн алдагдалтай, боловсруулах үйлдвэрлэл 680.2 (41.0%) сая төгрөгийн алдагдалтай, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 87.7 (12.7%) сая төгрөгийн ашиг алдагдалтай ажилласан байна.

ЗУРАГ 8.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БОРЛУУЛАЛТ, салбараар, сараар, тэрбум төгрөг



**Ойлголт, тодорхойлолт:**

**Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл:** Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн:** Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

**Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн (биет хэмжээний) индекс:** Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, Ласпейсийн биет хэмжээний индексийн томъёог ашиглан тооцно.

**Тооцох аргачлал:**

Ласпейсийн биет хэмжээний индексийн томъёо:

$$I_{LQ} = \frac{\sum(Q_t \cdot P_0)}{\sum(Q_0 \cdot P_0)} \cdot 100 = \sum\left(\frac{Q_t}{Q_0}\right) \cdot W_0 \cdot 100$$

Q<sub>t</sub>- Бүтээгдэхүүний тайлант үеийн биет хэмжээ

Q<sub>0</sub>- Бүтээгдэхүүний суурь үеийн биет хэмжээ

P<sub>0</sub>- Бүтээгдэхүүний суурь үеийн үнэ

W<sub>0</sub>- Жин



## НИЙТИЙН АЖ АХУЙ, 2023 оны эхний 3 сарын байдлаар

ᠨᠢᠶᠢᠲᠢᠢᠨ ᠠᠵᠢ ᠠᠬᠤᠢ

### ТЭЭВЭРЛЭСЭН ХОГ



2022 I-III 20.3

2023 I-III 66.6

### ЦЭВЭРЛЭСЭН ЗАМ ТАЛБАЙ - 2 880.3



### АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО - 2 954.2



Дүүргийн хэмжээнд 2023 оны 3 сард 2880.3 мян.м зам талбай цэвэрлэж, 66.6 мян.м хог тээвэрлэсэн байна. Ажил үйлчилгээний орлого 2 954.2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1 874.6 сая төгрөгөөр (2.7) дахин өссөн үзүүлэлтэй байна.



## IX. НИЙТИЙН АЖ АХУЙ

Чингэлтэй дүүргийн хувьд нийт цэвэрлэгээний ажил, хог хаягдлыг Тохижилт үйлчилгээний байгууллага болон Найши ХХК нь хариуцаж ажилладаг.

Дүүргийн хэмжээнд 2023 оны 3 сард 2880.3 мян.м<sup>2</sup> зам талбай цэвэрлэж, 66.6 мян.м<sup>3</sup> хог тээвэрлэсэн байна. Тээвэрлэсэн хог өмнөх жилийн мөн үеэс 46.3 мян.м<sup>3</sup> (3.2 дахин) өссөн байна.

Ажил үйлчилгээний орлого 2954.2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1874.6 сая төгрөгөөр (2.7 дахин) өссөн байна. Орлогын эх үүсвэрийг ангилбал 17.3% зам талбай, 47.4% гэр хорооллоос, 17.8% орон сууцнаас, 17.5%-ийг албан газраас олсон орлого тус тус эзэлж байна.

### ХҮСНЭГТ 9.1 ТОХИЖИЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛ, ОРЛОГО, жил бүрийн эхний 3 сар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 I-III	2022 I-III	2023 I-III	Өсөлт бууралт (хувь)
Цэвэрлэсэн талбай	мян.м <sup>2</sup>	3 512.8	1 513.0	2 880.3	1.9 <sup>1</sup>
Тээвэрлэсэн хог	мян.м <sup>3</sup>	17.5	20.3	66.6	3.2 <sup>1</sup>
Орон сууц	мян.м <sup>3</sup>	3.4	3.7	8.3	2.2 <sup>1</sup>
Гэр хороолол	мян.м <sup>3</sup>	9.7	11.6	40.6	3.5 <sup>1</sup>
Албан газар	мян.м <sup>3</sup>	2.4	2.8	9.9	3.5 <sup>1</sup>
Зам талбай	мян.м <sup>3</sup>	2	2.2	7.8	3.5 <sup>1</sup>
Ажил үйлчилгээний орлого	сая.төг	1 039.5	1 079.6	2 954.2	2.7 <sup>1</sup>
Зам талбай	сая.төг	176	172.4	512	3 <sup>1</sup>
Гэр хороолол	сая.төг	460.4	504.9	1 400.2	2.8 <sup>1</sup>
Орон сууц	сая.төг	176	172.9	526	3 <sup>1</sup>
Албан газар	сая.төг	227.1	229	516.0	2.3 <sup>1</sup>

\* Эх үүсвэр: Тохижилт нийтийн аж ахуйн газар



## Х. ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

Иргэний бүртгэлийн үйлчилгээ: 2023 оны 3 сард Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэний бүртгэлийн 8 төрлийн үйлчилгээ 14 068 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 5 541 (65.0%) хүнээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэрлэлт, эцэг тогтоосны бүртгэл буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 10.1 ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ХҮНИЙ ТОО, үйлчилгээний төрлөөр

Үзүүлэлт	2022 I-III	2023 I-III	$\frac{2023 \text{ I-III}}{2022 \text{ I-III}}$
	Дүнгээр		Хувь
<b>Нийт</b>	<b>8 527</b>	<b>14 068</b>	<b>65.0</b>
Шинэ төрсөн	579	619	6.9
Гэрлэлт	173	172	-6
Гэр бүл цуцлалт	55	80	45.5
Хүүхэд үрчлэлт	10	14	40.0
Эцэг тогтоосон	38	11	-71.1
Овог, нэр өөрчлөх	47	60	27.7
Шилжин ирсэн	352	378	7.4
Лавлагаа	5 207	6 802	30.6
Иргэний үнэмлэх олголт:	2 066	5 932	87.1
16 нас хүрч шинээр авсан	414	428	3.4
Дахин олголт	1 652	5 504	33.2

\* Эх үүсвэр: Иргэний бүртгэлийн хэлтэс



## ОНЦГОЙ БАЙДАЛ, 2023 оны эхний 3 сарын байдлаар

Тогтвортой  
Өсөлт

Онцгой байдлын хэлтэс нь 2023 оны эхний 3 сарын байдлаар 159 гал түймэр гамшиг ослын дуудлагаар ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс 43 тохиолдлоор буюу (37.1%) өссөн байна.



**Онцгой байдал:** Онцгой байдлын хэлтэс нь 2023 оны эхний 3 дугаар сард үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрт 159 гал түймэр гамшиг ослын дуудлагаар ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс 43 тохиолдлоор (37.1%) өссөн байна.

ХҮСНЭГТ 10.2 ГАЛ ТҮЙМРИЙН ДУУДЛАГА ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2023 оны эхний 3 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 I-III	2023 I-III	Өөрчлөлт %
<b>Дуудлагын тоо</b>	<b>Тоо</b>	<b>116</b>	<b>159</b>	<b>37.1</b>
Гал түймэр	Тоо	74	123	66.2
Иргэд унтраасан гал түймэр	Тоо	18	14	-22.2
Өөрөө унтраасан гал түймэр	Тоо	8	-	-
Худал дуудлага	Тоо	1	-	-
Ажилласан цаг	Цаг.мин	550	420	2.1 <sup>1</sup>
Ашиглагдсан ус	Тонн	241	82	-66
Ашиглагдсан шатхуун /дизель/	Литр	2 508	1 120	-55.3
Ашиглагдсан хөөс	Литр	-	-	-
Зарцуулсан мөнгө	Сая.төг	3.7	6.9	86.5
Аварсан хүний тоо	Тоо	77	92	19.5
Унтраасан барилга байшингийн тоо	Тоо	82	98	19.5
Нийт өмч хөрөнгө	Сая.төг	1 685	850	-49.6
Амьсгалын бие даасан төхөөрөмж	Тоо	133	82	-38.3

\* Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтэс

<sup>1</sup>-Дахин их






## ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, 2023 оны эхний 3 сарын байдлаар

Үйлчилгээний тоо  
 Үйлчилгээний хөлс (мян.төг)

	Эд хөрөнгийн бүртгэл	Газар	Газраас бусад
Үйлчилгээний тоо	2 770	995	1 775
Үйлчилгээний хөлс (мян.төг)	53 049.7	11 854.9	41 195.3

ҮҮНЭЭС: -----



**Эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ:** 2023 оны 3 сард Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь эд хөрөнгийн бүртгэлийн 7 төрлийн үйлчилгээг нийт 5540 иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлж, үйлчилгээний хөлсөнд 106.1 сая төгрөгийн хураамж авсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс үйлчилгээ авсан хүн 2884 (2.1 дахин) хүнээр буурч, үйлчилгээний хөлс 371.5 (3.1 дахин) сая төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 10.3 ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТОО, ТӨРЛӨӨР, ЭХНИЙ 3 САРД

Үйлчилгээний төрөл	Эд хөрөнгийн бүртгэл		Газар		Газраас бусад	
	Үйлчилгээний тоо	Үйлчилгээний хөлс (мян.төг)	Үйлчилгээний тоо	Үйлчилгээний хөлс (мян.төг)	Үйлчилгээний тоо	Үйлчилгээний хөлс (мян.төг)
<b>Нийт</b>	<b>2 770</b>	<b>53 049.7</b>	<b>995</b>	<b>11 854.9</b>	<b>1 775</b>	<b>41 195.3</b>
Анхны бүртгэл	287	1 876.5	90	0	197	1 876.5
Өмчлөх эрх шилжих гэрээ	1 045	20 900	372	7 440	673	13 460.0
Барьцааны гэрээ	1 205	28 767.2	468	3 963.4	737	24 803.8
Бусад гэрээ	18	135	0	0	18	135
Бүртгэлд өөрчлөлт оруулах	124	1 320	41	436	83	884
Урьдчилсан тэмдэглэл	7	15	2	5	5	10
Лавлагаа хуулбар	84	36	22	10.5	62	26

\*Эх үүсвэр: Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс

**Улаан загалмай:** Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2023 оны эхний 3 сард 3 139 хүнд 13 416.0 мянган төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 29 759 хүнээр, зарцуулсан зардал 2.3 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 10.4 ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ, ТӨРЛӨӨР

Үзүүлэлт	2022 I-III			2023 I-III		
	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/
<b>Дүн</b>	<b>302</b>	<b>32 898</b>	<b>15 716.0</b>	<b>33</b>	<b>3 139</b>	<b>13 416.0</b>
Халамж үйлчилгээ	131	570	6 935.0	2	267	645.0
Халамжийн чиглэлээрх сургалт, сурталчилгаа	10	169	35	14	259	771.0
Анхны тусламжийн сургалт	22	356	65	4	418	-
Эрүүл мэндийг дэмжих сургалт, сурталчилгаа	50	13 892	8 035.0	-	-	-
Гамшгийн тусламж	-	-	-	-	-	-
Гамшгийн талаарх сургалт, сурталчилгаа	31	14 523	336	4	1 769	-
Донорын өдөрлөг, сурталчилгаа	5	574	-	-	-	-
Хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээрх сургалт, сурталчилгаа	26	1 213	100	5	298	-
Хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7 зарчим, ТУЗХА-ны сурталчилгаа	27	1 601	210	4	128	12 000.0

\*Эх үүсвэр: Улаан загалмайн хороо

Халамжийн чиглэлээрх сургалт, сурталчилгааг 14 удаа зохион байгуулж 259 иргэн, анхны тусламжийн сургалт 4 удаа зохион байгуулж 418 иргэн, гамшгийн талаарх сургалт, сурталчилгааг 4 удаа зохион байгуулж 1769 иргэн, хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээрх сургалтыг 5 удаа зохион байгуулж 298 иргэн, хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7-н зарчим, төр, Улаан загалмайн хамтын ажиллагааны сурталчилгааг 4 удаа зохион байгуулж 128 иргэнийг тус тус хамруулсан байна.

**Захиргааны мэдээлэл:** Дүүргийн хэмжээнд 2023 оны эхний 3 дугаар сард 903 иргэдээс өргөдөл, гомдол ирснээс 826-г хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэж, 77 нь шийдвэрлэх шатандаа хянагдаж байна. Нийт ирүүлсэн өргөдөл гомдлын 91.5 хувийг шийдвэрлэж хариу өгсөн байна.

ХҮСНЭГТ 10.5 ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ, хүлээн авсан нэгжийн ангиллаар, 2023 оны эхний 3 сарын байдлаар

Ангилал	2023 он I-III сар	Үүнээс:	
		Шийдвэрлэх шатандаа байгаа	Шийдвэрлэж хариу өгсөн
<b>Нийт</b>	<b>903</b>	<b>77</b>	<b>826</b>
Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв	8	-	8
Нутгийн захиргааны байгууллагууд	522	42	480
1800-1200 дугаарын оператор	26	5	21
11-11 төвөөс ирсэн	324	20	304
Гар утасны аппликэйшнээр ирсэн	1	-	1
Мессеж	-	-	-
E-Service	4	1	3
Facebook	-	-	-
Дижитал сити	18	9	9
Хороо бүртгэсэн	-	-	-
НМХГ тусгай дугаар	-	-	-

\* Эх үүсвэр: Иргэний бүртгэлийн хэлтэс

Танилцуулга хянасан:

Д.Мөнхзул

Г.Пүрэвсүрэн

Танилцуулгыг нэгтгэсэн:

Г.Пүрэвсүрэн

